



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 593

Улаанбаатар хот

“Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалтын
бодлогын баримт бичиг”-ийг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 1.2, 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалтын бодлогын баримт бичиг”-ийг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны 2021
оны 12 дугаар сарын 22-ны өдрийн
593 дугаар тогтоолын хавсралт



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БОДЛОГЫН
БАРИМТ БИЧИГ**

2021 он

УДИРТГАЛ

Дэлхийн санхүүгийн зах зээлд технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ /fintech/, зохицуулалт /regtech/ мөн хяналт шалгалт /supotech/ хурдацтай хөгжиж буй энэ үед Хорооны хяналт шалгалтын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлж Хорооны хяналт шалгалтын бодлогын боловсруулж, бодлогын зорилго, зорилт, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон тус бодлогыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, хяналт шалгалтын хамрах хүрээ, үе шатыг энэхүү бодлогын баримт бичигт тодорхойлов. Хорооны хяналт шалгалтын бодлогоор дамжуулж чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэх болно.

Хорооны хяналт шалгалтын бодлогын баримт бичгийн агуулга, бүтцийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу боловсруулсан. Тус баримт бичиг нь 2 үндсэн бүлгээс бүрдэх бөгөөд эхний бүлэгт өнөөгийн байдлаар Хорооноос баримталж буй хяналт шалгалтын тогтолцоо, аргачлал, зарчим, үе шат, төрлүүдийн талаар дэлгэрэнгүй тодорхойлсон бол хоёрдугаар бүлэгт Хорооны хяналт шалгалтыг боловсронгуй болгох дунд хугацааны төлөвлөгөөг суурь 6 зорилго, 21 зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд тодорхойлсон. Бодлогын хяналт шинжилгээ-үнэлгээний шалгуур үзүүлэлтийг дагалдан гарах Хорооны хяналт шалгалтын бодлогыг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний баримт бичигт тусгах бөгөөд энэхүү баримт бичиг нь цаашид дунд болон урт хугацааны стратеги, төлөвлөлт хийхэд баримтлах залгамж чанартай үндсэн баримт бичиг болох ач холбогдолтой юм.

Энэхүү баримт бичгийг боловсруулахдаа Базелийн хороо, Олон улсын валютын сан, IOSCO буюу Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага, IAIS буюу Олон улсын даатгалын хянан шалгагчдын холбоо зэрэг олон улсын гишүүнчлэл бүхий байгууллага, ФАТФ буюу Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага зэрэг холбогдох эрх бүхий байгууллагуудын стандарт, Монгол Улсын хууль тогтоомж, шаардлагууд болон Канад, Сингапур, Бритиш, Колумбия, Япон, БНСУ, Исланд, Энэтхэг, Австрали зэрэг улсуудын хяналт шалгалтын гарын авлага, зааврыг үндэс болгов.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХҮРЭХ ТҮВШИН, АЧ ХОЛБОГДОЛ

Улс орнууд хяналт шалгалтын зарчим, аргачлал, үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэрэгсэл, хамрах хүрээ, тогтолцоо зэргийг салбарын хууль тогтоомжид тусгаж, бодлогын баримт бичгийн хүрээнд албан хаагчдын нийтлэг дагаж мөрдөх дүрэм хэлбэрээр хэрэгжүүлдэг. Бодлогын баримт бичгийг боловсруулснаар хийгдэж буй хяналт шалгалтын бодлогыг зохистой түвшинд тодорхойлох, авах арга хэмжээ нь зах зээлийн шаардлагад нийцсэн байх, хэрэгжүүлж буй хяналт шалгалт нь тодорхой процедурын дагуу хийгдэх, эрсдэлтэй үйл ажиллагааг оновчтой тодорхойлох зэрэг эерэг нөхцөл байдлыг бий болгоно.

Хорооноос хяналт шалгалтыг технологид суурилсан хэлбэрээр буюу хянан шалгалтыг гүйцэтгэх технологи (supotech), зохицуулалтын технологи (regtech)-ийн хосолмол байдлаар хэрэгжүүлэх асуудлыг тэргүүн чиглэл бол иллахаар зорьж байна.

Иймд Хорооны зохицуулалттай салбаруудын зах зээлийн онцлог, оролцогчдын тоо хэмжээ, ирээдүйд тулгарах эрсдэлүүд өдөр өдрөөр хувьсан өөрчлөгдөж, улам нэмэгдэх чиг хандлагатай байгаа тул үүнд хяналт тавьж буй албан хаагчдын хязгаарлагдмал нөөц бололцоог үр дүнтэй хуваарилах, цаашлаад шинээр нэмэгдэх зохицуулалттай салбарын үндсэн суурийг бий

болгох, хяналтын бодлогыг зөв тодорхойлох зэрэг ухаалаг, үр дүнтэй зохицуулалтын орчныг бий болгох шаардлага үүсээд байна. Үүний дагуу авч хэрэгжүүлбэл зохих эхний арга хэмжээ нь “Хяналт шалгалтын бодлогыг баримт бичиг” байх бөгөөд тус баримт бичгийг бүхий л үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, үүсэж буй нөхцөлд байдалд нийцүүлэн шинэчлэх зэргээр ашиглах “амьд бодлогын баримт бичиг” юм.

“Хяналт шалгалтын бодлогын баримт бичиг” нь зохицуулалттай этгээд, хянан шалгагчид болон иргэдэд зориулагдсан бөгөөд ирээдүйд Хороо хяналт шалгалтын үйл ажиллагаанд баримтлах зарчим, хандлага, хүрэх замыг тодорхойлж, тэдний ойлголтын нэг цэгт төвлөрүүлэхэд дэмжлэг болох ач холбогдолтой юм.



БҮЛЭГ 1.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ӨНӨӨГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОГТОЛЦОО

БҮЛЭГ 1-ИЙН АГУУЛГА

– ЗУРАГ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

1. ХОРООНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Хорооны чиг үүрэг 3

1.2 Хорооны зохицуулалттай салбарын хамрах хүрээ 3

1.3 Хорооны хяналт шалгалтын бүтэц 3

2. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗАРЧМУУД..... 4

3. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА 9

3.1 Байгууллага тус бүрийн эрсдэлийн үнэлгээ 9

3.2 Салбарын эрсдэлийн үнэлгээ..... 10

3.3 Эрсдэлийг удирдах, хянах, бууруулах нь..... 11

4. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЕ ШАТ..... 12

4.1 Зах зээлд нэвтрэхэд тавих хяналт..... 12

4.2 Сургалт, мэдээллээр хангах..... 13

4.3 Зайны хяналт шалгалт..... 13

4.4 Газар дээрх хяналт шалгалт..... 13

4.5 Зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ..... 14

4.6 Гүйцэтгэлийн хяналт шалгалт..... 14

5. ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨРЛҮҮД.....16

5.1 Эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалт16

5.2 Прудент буюу Зохистой байдлын хяналт шалгалт17

НЭГ. ХОРООНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. Хорооны чиг үүрэг

Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага ба холбогдох хуулийн хэрэгжилт болоод өөрийн үйл ажиллагааныхаа талаар жил тутам Улсын Их Хуралд тайлагнадаг, түүний харьяа байгууллага болно. Хорооны үйл ажиллагааны нэг салшгүй, томоохон чиглэл бол ХЯНАЛТ ШАЛГАЛТ юм.


1.2. Хорооны зохицуулалттай салбарын хамрах хүрээ

Хороо анх байгуулагдахдаа банкнаас бусад санхүүгийн салбарыг хариуцахаар хуульчлагдаж, үүнд нь үнэт цаасны салбар, даатгалын салбар, бичил санхүүгийн салбарын зохицуулалт хамрагдаж байсан бол нийгмийн хэрэгцээ, шаардлага, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хөрөнгийн зах зээл болон даатгалын салбарын шинээр бий болж буй зах зээлийн харилцааг төрөлжүүлэн хянаж, түүнээс гадна санхүүгийн бус бизнес, мэргэжлийн оролцогчид болох үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг өөрийн зохицуулалтад хамруулан бүртгэл, бодлого болон хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. ФАТФ-ын техник зөвлөмж 15 /Шинэ технологи/-д нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг зохицуулалтад хамруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлуудыг авч хэрэгжүүлж, зохицуулалтыг бүрдүүлэх ажлууд хийгдэж байгаа бөгөөд Хорооны зохицуулалттай салбарын хамрах хүрээ тэлэгдэхийн хэрээр ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ улам өргөжин тэлэх хандлагатай байна.

1.3. Хорооны хяналт шалгалтын бүтэц

Хороо гүйцэтгэлд суурилсан хяналт шалгалтаас эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо руу шилжихээр холбогдох баримт бичгүүдийг боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Зураг 1. Ерөнхий хяналт шалгалт /зохицуулалтын тогтолцоо/



Зохицуулалттай этгээдэд хяналт шалгалтыг зайны болон газар дээрх гэсэн хоёр хэлбэрээр хийж илэрсэн зөрчил, дутагдлыг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийнхээ хүрээнд арилгуулах арга хэмжээг тухай бүр авах, захиргааны хариуцлага ногдуулах, зөрчлийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх, гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл хууль хяналтын байгууллагад мэдээлэл хүргүүлэн шалгуулах ажлыг өдөр тутамд зохион байгуулж байна. Мөн зохицуулалтын зах зээлд

оролцогчдоос Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдолд үндэслэн зайны болон газар дээрх хяналт шалгалт хийж, дүгнэлт гарган хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж байна.

Газар дээрх хяналт шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус байдлаар хийдэг ба шалгалтыг хамрах цар хүрээгээр нь иж бүрэн, хэсэгчилсэн, үзлэг гэж ангилдаг.

Зайны хяналт шалгалтыг Хорооны зохицуулалттай этгээд хууль тогтоомжид заасан хугацаанд цаасаар болон цахимаар ирүүлсэн санхүүгийн болон нэмэлт тайланд тогтмол хугацааны давтамжтай хийж байна.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗАРЧМУУД

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, зохицуулалттай салбаруудыг бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох, бодлогоор зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хянаж шалгах чиг үүргийнхээ хүрээнд Хороо олон улсын стандартыг баримталж чиг үүргээ хэрэгжүүлж ажиллана. Энэхүү бодлогын баримт бичиг нь Хорооноос хийх хяналт шалгалтын суурь зарчим, тогтолцоо болон бодлогыг тодорхойлно. Хороо хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ дараах үндсэн зарчмуудыг суурь болгож ажиллана.

ЗАРЧИМ 1. ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

1.1 Эрсдэлийн хэмжээнээс хамааруулж хяналт шалгалтын давтамж, цар хүрээг тодорхойлох;

Зохицуулалттай этгээдүүдэд нэгэн ижил хэлбэрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бус, тухайн байгууллагын эрсдэлийн түвшинг үнэлсний үндсэн дээр эрсдэлийн хэмжээнээс хамааруулж, хяналт шалгалтын давтамж, цар хүрээг тодорхойлж, хэрэгжүүлэх

1.2 Зохицуулалттай этгээд тус бүрийн эрсдэлийг үнэлж, дүгнэлт хийх;

Тайлан, мэдээ, зохистой харьцаа болон төлбөрийн шалгуур үзүүлэлт, эрсдэлийн үнэлгээний асуулга, зайны хяналтын мэдээлэл, салбарын эрсдэлийн түвшин, бизнесийн эрсдэл зэрэг олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг ашигласны үндсэн дээр зохицуулалттай этгээд тус бүрийн эрсдэлийг үнэлж, шинжлэн, дүн шинжилгээ хийнэ.

1.3 Хяналт шалгалтын хязгаарлагдмал нөөцийг эрсдэлийн түвшинтэй уялдуулан оновчтой тараан байршуулснаар эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх

Эрсдэл үүсэх давтамж, нөлөөллийг шинжилж үзсэний үндсэн дээр хяналт шалгалтын хязгаарлагдмал нөөц бололцоог ухаалаг, үр ашигтай хэлбэрээр тараан байршуулна.

1.5 Системчилсэн, ухаалаг байх;

Системчилсэн байдлаар эрсдэлийг тодорхойлох гэдэг нь эрсдэл хэрхэн бодит болох (crystallize) “*магадлалыг*” (likelihood) тухайн эрсдэлээс бий болсон “*үр нөлөө*” (impact)-тэй харьцуулснаар тодорхойлогдоно. Мөн ухаалаг хэрэглээ хөгжиж буй өнөө үед хүний оролцоог багасгах, цаг хугацааг хэмнэх зорилгоор цуглуулж буй өгөгдлийг ухаалаг байдлаар цуглуулж нэгтгэдэг байхыг ойлгоно.

1.6 Оноонд суурилсан (score-based) хяналтыг тогтмол хэрэгжүүлдэг байх;

Ононд суурилсан хяналтын аргачлал нь нийт зохицуулалттай этгээдүүдийг хооронд нь харьцуулах, тухайн салбарт учирч буй нийтлэг эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг бууруулахад чиглэсэн зөв, зохистой арга хэмжээ авахад гол зорилго оршино.

1.7 Олон талын эх сурвалжийг ашигладаг байх;

Зохицуулалттай этгээдийг зөвхөн илгээсэн асуулга, тоон үзүүлэлтээр үнэлдэг хязгаарлагдмал аргачлалаас зайлсхийж, илүү өргөн хүрээнд буюу системийн эрсдэл, макро эдийн засгийн эрсдэл, байгууллагын онцлог эрсдэл (ёс зүй гэх мэт) зэргийг харьцуулж хардаг байхыг ойлгоно.

1.8 Хяналт шалгалт байнгын, үргэлжилсэн байх;

Байгууллагын эрсдэлийг тодорхойлохдоо зөвхөн асуулга, тоон үзүүлэлтээр үнэлэх нь учир дутагдалтай. Ононд суурилсан хяналтыг жилд тодорхой хугацаанд хэрэгжүүлэхээс гадна үргэлжилсэн, байнгын хяналтын тогтолцоонд шилжих ёстой. Тухайлбал, хяналт шалгалтын төлөвлөгөө гаргах, газар дээрх болон зайны хяналтыг хэрэгжүүлэх, хувийн хэргийг шинэчлэх, авах арга хэмжээг тодорхойлох, үнэлэх, авсан арга хэмжээ болон хувийн хэргийг хянах, хяналт шалгалтын төлөвлөгөө гаргана.

ЗАРЧИМ 2. УЛАМЖЛАЛТ БОЛОН ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХОСОЛСОН ҮР АШИГТАЙ, ОНОВЧТОЙ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ХҮРЭЭНД

Дэвшилтэт технологид суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд шилжсэнээр цуглуулж буй өгөгдөл, мэдээллийг оновчтой ашиглах, зохицуулалттай этгээдэд тулгарч буй бодит эрсдэлийг урьдчилан тооцоолох, эрсдэлийг бууруулах, цаашлаад эдийн засгийн олон тулгуурт санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, хүртээмж, салбаруудын дэд бүтэц, оролцогчдын мэдлэг мэдээллийг сайжруулах боломж бүрдүүлэх замаар санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж түүнд үзүүлэх мөчлөгийн нөлөөг багасгах таатай орчин бүрдэнэ. Түүнчлэн дэвшилтэт технологи санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийн өргөжүүлэх томоохон хөшүүргүүдийн нэг юм.

Технологид суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ Хороо нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хуульд заасан үндэслэл журмын дагуу хийх бөгөөд тасралтгүй хэлбэрээр хэрэгжүүлнэ. Хорооноос инноваци, дэвшилтэт технологийг дэмжихийн сацуу зохистой эрх зүйн орчныг бүрдүүлж, бодлогоор зохицуулж, эрсдэлд суурилсан хэлбэрээр хяналт шалгалт хэрэгжүүлэх бодлогыг баримталдаг. Тухайлбал, Сэндбокс зохицуулалтын орчныг Монгол Улсад анх удаа нэвтрүүлж, бизнесийн шинэ загвар, модель, инновацийг дэмжих, зохицуулагч байгууллагын зүгээс нягт хамтран ажиллах, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээ турших боломжийг олгохын сацуу санхүүгийн технологийг зохицуулах оновчтой эрх зүйн бүрдүүлэх чиглэлд ажиллаж байна.

Тухайлбал, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Монгол Улсад Финтек эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоог хөгжүүлэх нь” цахим санхүүгийн үйлчилгээ, блокчэйнд суурилсан виртуал хөрөнгийн үйлчилгээ, сэндбокс хөтөлбөр зэргийг хамруулсан төслийг хэрэгжүүлэх бөгөөд үндсэн хэрэгжүүлэгч нь Хороо байхаар шийдвэрлэсэн.

Цахим санхүүгийн үйлчилгээний шинэ загвар болох төвлөрсөн бус системд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт, нийлүүлэлт, бизнесийн загвар нь санхүүгийн систем, эдийн засагт багагүй өөрчлөлтүүдийг бий болгосон. Хорооноос инновацийг дэмжиж, үүдэх эрсдэлийг

бууруулах, урьдчилан сэргийлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бий болгох чиглэлд ажиллаж байна.

Хороо технологид суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэхэд дараах зарчмыг баримтална.

2.1 Мэдээллийн аюулгүй байдал, кибер эрсдэлээс хамгаалах;

Технологид суурилсан хяналт шалгалтын суурь нь мэдээллийг өгөгдөл байх тул автоматжуулсан мэдээлэл солилцох, өгөгдлийг хамтран ашиглах, өгөгдлийн баазад хандахтай холбогдох зохицуулалтыг чанга мөрдөж мэдээллийн аюулгүй байдлын хангаж кибер халдлага түүний дотор мэдээллийн алдагдлаас хамгаална.

2.3 Хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай хуваарилсан, чадварыг нэмэгдүүлсэн байх;

Хяналтын технологи нь цаг хугацаа, хүний нөөц гэх мэт хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай хуваарилсан, нарийн төвөгтэй хяналт шалгалтыг хийж чадахаар програмчлагдсан байна.

2.4 Өгөгдөл нь мэдээллийн стандартыг хангасан байх;

Санхүүгийн зах зээлд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаа дижитал хэлбэрт шилжиж, нийлүүлэх өгөгдөл нь мэдээллийн стандартчилал, өгөгдлийн чанар, өгөгдлийн зөрүүгүй, бүрэн байдал нь үр дүнтэй технологид суурилсан хяналтын чухал нөхцөл болно.

2.5 Хяналт шалгалт нь тасралтгүй байх;

Дэвшилтэд технологи нь санхүүгийн байгууллагуудын харилцаа уялдааг хангасан микро болон нэгтгэсэн макро өгөгдлийг тасралтгүй үүсгэх боломжтой тул зөрчил илрүүлэх, эрсдэлд суурилсан хяналт, макро болон микро зохистой /prudential/ хяналт, зах зээлийн сурвейлансыг байршил, цаг хугацаанаас үл хамаарч тасралтгүй хийх боломжтой байна.

2.6 Хяналтын тайлан нь уян хатан, хэрэгцээ шаардлага хангасан байх;

Зохицуулалттай этгээдүүдийн өгөгдөлд хяналт хийж, дүн шинжилгээ хийх программууд нь өгөгдлийг баталгаажуулах, нэгтгэх, дүрслэх, стресс тестийн үйл ажиллагааг автоматжуулж, тайлан гаргах явцыг оновчтой болгож, хянагч, бодлого боловсруулагчдад хэрэгцээт чухал ач холбогдолтой мэдээлэл өгдөг байх. Мөн бодит цагийн эрсдэлийн индикаторын хяналтын самбар, эрт сэрэмжлүүлэх систем зэрэг тайлангуудыг агуулсан байна.

ЗАРЧИМ 3. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ХҮРЭЭНД

Хэрэглэгч, хөрөнгө оруулагч өөрсдийн ашиг сонирхлыг хамгаалах үндсэн үүргийг хүлээж, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгох, хөрөнгө оруулахад зохих ёсоор анхааралтай хандах хэрэгтэй. Хэрэглэгчийн сонголт, хөрөнгө оруулалтаас хүлээгдэж буй үр өгөөжийг өгөхгүй байх эрсдэлээс хамгаалах боломжгүй ч, Хороо хэрэглэгч, хөрөнгө оруулагчийг санхүүгийн боловсролыг нэмэгдүүлж, өөрсдийгөө хамгаалах үндсэн үүрэг хариуцлагыг хүлээх боломжийг олгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгч хоорондын мэдээллийн болон эрх мэдлийн тэгш бус байдлыг бууруулах замаар хэрэглэгчийн эрхийг хамгаалснаар санхүүгийн салбарт ил тод байдал, сахилга бат, санхүүгийн салбарын суурь эрсдэлийг бууруулах, шударга өрсөлдөөнт орчин, бизнесийн тогтвортой байдал бий болох ач холбогдолтой юм. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

3.1 Хэрэглэгчдийг хамгаалахын тулд бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулахаас илүүтэйгээр байгууллагууд цаг тухайд нь, үнэн зөв, бүрэн мэдээллээр хангахыг шаардах;

Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, нөхцөл, болзол, түүнд агуулагдах эрсдэлүүдийн талаарх бүрэн гүйцэд, ойлгомжтой, зохистой, харьцуулж болохуйц мэдээллээр хэрэглэгч, хөрөнгө оруулагчийг цаг тухайд нь, үнэн зөв, бүрэн хангаж байгаа эсэхэд хяналт тавина.

3.2 Санхүүгийн маргаан таслах олон талт механизмтай байх;

Аливаа өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг хараат бус, шударга, хариуцлагатай, цаг тухайд нь, үр ашигтай, бага зардалтай байх механизмаар хангах ёстой. Ийм механизм нь хэрэглэгчдэд үндэслэлгүй зардал, саатал, дарамт учруулах ёсгүй. Хэрэглэгчдийг санхүүгийн луйвар, зүй бус ашиглалт, алдаанаас хамгаалах, хариуцлага хүлээлгэх хүчтэй, үр дүнтэй хууль, шүүхийн болон хяналтын механизмуудтай байна.

3.4 Санхүүгийн хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг хангах;

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчийн мэдээллийг ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр хэрэглэгчийн дэлгэрэнгүй мэдээлэл, түүний дотор хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах ёсгүй.

3.5 Үйлчлүүлэгчдэд тэгш, шударга ханддаг байх;

Санхүүгийн бүх хэрэглэгчид санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй харилцах бүхий л үе шатанд эрх тэгш, шударгаар хандах боломж олгогдсон байна. Хэрэглэгчийн санхүүгийн чадвар, нөхцөл байдал, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, дижитал бичиг үсэг тайлагдсан байдал зэргийг харгалзан үзэх ёстой.

ЗАРЧИМ 4. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ХҮРЭЭНД

Хяналт шалгалтын үр дүн, шийдвэр олон нийтэд нээлттэй, ил тод болгож, олон нийтийн хяналт, судалгааг эргэлтэд оруулснаар шударга ёсны хүртээмж нэмэгдэнэ. Хяналт шалгалтын мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:


1. Хууль зүйн техникийн хэлбэрийн шаардлага (хууль зүйн хэл, найруулга, хэв маяг, нэр томьёо, бүтэц гэх мэт)-ыг хангасан байх;
2. Хяналт шалгалтын шийдвэрийн үндэслэлийг дэлгэрэнгүй, ойлгомжтой тодорхойлсон байх;
3. Мэдээлэл нь үнэн, бодитой, үндэслэл бүхий нэгдмэл арга зүй, олон улсын стандарттай нийцсэн, мэдээллийн нууцлалыг хадгалж, хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд ил тод байх;
4. Нийтлэх үйл ажиллагаа нь хараат бус, бие даасан, шуурхай байх;
5. Хяналт шалгалтын цахим нэгдсэн сан болон цахим хуудас кибер аюулгүй байдлыг бүрэн хангасан байх;
6. Судалгааны дүн шинжилгээ, үндэслэл, үнэлгээ дүгнэлт нь нотолгоонд тулгуурлаж, үр дүн нь улс төр, үзэл суртал, шашны үзлийн нөлөөллөөс ангид байх.

Хорооноос хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ баримтлах дээрх зарчмуудаас гадна хянан шалгагч нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хариуцлагатай, ёс зүйтэй, мэргэшсэн байж холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөн нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллана.

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлд суурилсан аргачлал гэдэг нь зохицуулалттай этгээдүүдийн хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг нэг бүрчлэн шалгадаг, зөрчил үйлдсэн тохиолдолд торгууль оногдуулдаг тогтолцооноос ялгаатай. Дээрх тогтолцооны дутагдалтай тал нь зөвхөн өнгөрсөн болон өнөөдрийн учирч буй (статик) эрсдэлийг илрүүлдэг. Харин эрсдэлд суурилсан аргачлалыг олон улсад нийтлэгээр ашигладаг бөгөөд энэ нь тухайн байгууллагын тухайн цаг үед болон ирээдүйд бий болох эрсдэлийг тодорхойлж, үүн дээр шинжилгээ хийж үнэлгээ боловсруулан, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг цогц системийг ойлгоно. Эрсдэлд суурилсан аргачлал нь хязгаарлагдмал нөөц бололцоог ухаалгаар ашиглах боломжийг бий болгож, эрсдэлээс урьдчилан сэргийлэхийг зорьдог.

Зураг 2. Эрсдэлийн үнэлгээний үе шат



3.1 Байгууллага тус бүрийн эрсдэлийн үнэлгээ


Байгууллага тус бүрийн эрсдэлийн үнэлгээ гэдэг нь онооны системд суурилсан тоон болон чанарын асуулгыг нийт зохицуулалттай байгууллага тус бүрээс авч нэгтгэн боловсруулсан байх бөгөөд байгууллагуудыг хооронд нь харьцуулсан байдлаар дүгнэлт гарган тус бүрд эрсдэлийн мэдээллийн санг үүсгэнэ. Өөрөөр хэлбэл аль байгууллага нь эрсдэл өндөртэй, аль нь эрсдэл багатай байна гэдгийг тодорхойлно.

Хянан шалгагч нь сар, улирал, жилээр зохицуулалттай этгээдээс ирүүлсэн санхүүгийн болон зохистой харьцааны тайлангийн хүрээнд зохистой харьцаа, активын чанар, өгөөж зардлын түвшин, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, хөрөнгийн хүрэлцээтэй байдал зэрэг үзүүлэлтүүдээр эрсдэлийг үнэлнэ. Мөн үүнээс гадна бизнесийн эрсдэл буюу үйл ажиллагаа, бүтээгдэхүүн

үйлчилгээ, харилцагч, түгээлтийн суваг, засаглал, дотоод хяналттай холбоотой эрсдэлүүд, бүтцийн эрсдэл буюу эзэмшлийн хэлбэр, хүний нөөцийн хангамжаас үүдэлтэй эрсдэлүүдийг тооцно.

Үүний дараагаар нөлөөллийн шинжилгээг байгууллага тус бүрд хийж гүйцэтгэх ба тухайн байгууллагын санхүүгийн системийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлж буйд хянан шалгагчийн зүгээс янз бүрийн эх үүсвэр ашиглан /удирдлагатай хийх ярилцлага, тоон болон чанарын асуулга гм./ тооцоолол хийнэ. Тухайн байгууллагын зайны болон газар дээрх хяналт шалгалтын давтамж, цар хүрээг тодорхойлохдоо эрсдэлийн үнэлгээ ба нөлөөллийн шинжилгээ хоёрын нэгтгэлийн үр дүнд үндэслэнэ. Ерөнхий үйл явцыг дараах зургаас харах боломжтой.

Зураг 3. Эрсдэл ба нөлөөллийн загварчлал



Хороо нь байгууллага тус бүрийн эрсдэлийг үнэлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээний программ хангамжийг дотооддоо ашигладаг бөгөөд үнэлгээний нэгтгэлээс салбарын эрсдэлийн үнэлгээний ерөнхий зураглал гарч ирнэ.

3.2 Салбарын эрсдэлийн үнэлгээ

Хянан шалгагч нь эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэйд тооцогдсон салбаруудад боломжит нөөцийг илүү хуваарилснаар хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой болох тул салбарын эрсдэлийн үнэлгээ нь хяналт шалгалтын нэг чухал хэсэг юм.

Салбарын эрсдэлийн үнэлгээг байгууллагын эрсдэлийн үнэлгээний аргачлалтай адил зарчмаар үнэлнэ. Байгууллага тус бүрийн эрсдэлийн үнэлгээний үр дүн дээр салбарын төрөлхийн эрсдэл, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал болон бусад макро хүчин зүйлс зэрэг нэмэлт нөлөөллүүдийг харгалзан үзсэнээр салбарын эрсдэлийн нэгдсэн үнэлгээ гарч ирэх юм. Салбарын төрөлхийн эрсдэлийг салбарын хэмжээ, үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, тэдгээрийг хүргэх суваг, эргэлтэд буй нийт хөрөнгийн хэмжээ зэрэг хэд хэдэн хүчин зүйлийн дагуу үнэлнэ.

Эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсний дараагаар тухайн салбарын улс орны нэр хүнд, эдийн засаг, нийгэмд хэрхэн нөлөөлж буйд нөлөөллийн шинжилгээг хийх бөгөөд эрсдэлийн үнэлгээ, нөлөөллийн шинжилгээнээс гарч ирсэн нэгдсэн үр дүнг матрицад дараах байдлаар байршуулна.

Зураг 4. Эрсдэлийн матриц

Нөлөөлөл	Эрсдэл				
	Бага	Дунджаас доогуур	Дундаж	Дунджаас дээгүүр	Их
Их					
Дунджаас дээгүүр	+		+	+	+
Дундаж		+			
Дунджаас доогуур		+			
Бага					

Салбар бүрийн эрсдэлийг үнэлэн матрицад байршуулснаар эрсдэлд тохирсон хяналтын аргуудыг тодорхойлох боломжтой болох ба эрсдэлийн түвшин нэмэгдэх тусам хяналтын арга улам нарийсна. Тухайлбал, бага эрсдэлтэй салбарт үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдүүдэд зайнаас тавих хяналтыг түлхүү ашиглан газар дээрх хяналт шалгалтын эрчмийг бууруулах бол өндөр эрсдэлтэй салбарт газар дээрх хяналт шалгалтыг эрчимтэй хэрэгжүүлэн байнгын хяналт тавьж ажиллана.

3.3 Эрсдэлийг удирдах, хянах, бууруулах нь

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ үүссэн эрсдэл болон үүсэж болох эрсдэлийг тодорхойлж тэдгээрийг бууруулах арга хэмжээ авахыг ойлгоно. Энэ тохиолдолд олон төрлийн санхүүгийн гэмт хэрэг нуун далдлах зорилгоор мөнгийг хувиргасан байх эрсдэл үүсэж болох тул үйл ажиллагаандаа ямар төрлийн харилцагчийг таньж мэдэх, тулган шалгах үүргийг хэрэгжүүлэх шаардлагатайгаа тодорхойлж эрсдэлийг бууруулах арга хэмжээг авах шаардлагатай.

ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ 01

- Бизнесийн хэмжээ, үйл ажиллагааны онцлогийг тодорхойлох
- Байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ, харилцагчдын онцлогийг тодорхойлох
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний хүргэх сувгийг тодорхойлох
- Гадаад улс оронд үйл ажиллагаа явуулдаг, гадаадын харилцагчтай эсэх

ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ 02

- Үйлчлүүлэгч эсвэл бүтээгдэхүүний төрөл бүрд эрсдэл учрах магадлалыг тооцох
- Эрсдэлийн нөлөөллийг тооцох
- Олон улсын гүйлгээний хэмжээ, бэлэн мөнгөний эргэлт, харьцаа үзүүлэлтийн зохистой байдлыг тооцоолох

ЭРСДЭЛИЙН МАТРИЦ 03

- Нөлөөлөл болон эрсдэлийн магадлалд үндэслэн матриц боловсруулах

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА 04

- Үнэлгээнд үндэслэн хяналт шалгалтын аргыг тодорхойлох
- Журам, процедурыг тодорхойлох

ХЯНАЛТ 05

- Учирч болзошгүй эрсдэлд тогтмол хяналт тавих.
- Шинэ бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ нэвтрүүлсэн эсэхийг хянах.
- Хууль эрх зүйн орчин өөрчлөгдсөн эсэх, өөрчлөгдсөн тохиолдолд үүнтэй нийцүүлэн авч буй хариу арга хэмжээг хянах

ДӨРӨВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЕ ШАТ

4.1 Зах зээлд нэвтрэхэд тавих хяналт /Тохиромжтой этгээд/

Хорооны зохицуулалттай банкнаас бусад санхүүгийн салбарын оролцогч хүн, хуулийн этгээдэд тохиромжтой этгээдийн шалгуур тавигдах шаардлагатай бөгөөд салбарын хууль тогтоомж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн системийг уг гэмт хэрэгт өртөх эрсдэлийг бууруулахад санхүүгийн салбарт орж ирэх оролцогчдыг хянах, гарал үүсэл нь тодорхойгүй, хууль бус үйл ажиллагаанаас олсон орлого, мөнгө угаах зорилготой этгээдийг санхүүгийн системд нэвтрүүлэхгүй байхтай холбоотой зах зээлд нэвтрэн орохоос эхлэн үйл ажиллагаа явуулахад тохиромжтой этгээд мөн эсэхийг тогтоох шаардлагатай.

Зах зээлд нэвтрэн орж буй тусгай зөвшөөрөл хүсэгч болон тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд тэдгээрийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, хувь хүн, хуулийн этгээдэд ялгамжтай байдлаар тогтоохоос гадна цаашлаад хуулийн этгээдийн өмчлөгч, эцсийн өмчлөгч хүртэл тавигдах ба дараах тохиолдолд тохиромжтой этгээдийн шалгуур тавигдана. Үүнд:

- Хорооны зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж буй, эсхүл тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авахаар Хороонд хандсан;
- Тусгай зөвшөөрөлтэй этгээдийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хадгаламж, зээлийн хоршооны сонгуульт гишүүдэд өөрчлөлт оруулахаар Хороонд хандсан;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдөн бүртгүүлэхээр Хороонд хандсан;
- Зайны болон газар дээрх хяналт шалгалт явуулахад

Тохиромжтой этгээдийг тодорхойлох явцад цуглуулсан баримт материал, мэдээлэлд үндэслэн шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалт явуулах, илэрсэн зөрчил дутагдалд албадлагын арга хэмжээ авах, цаашлаад гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл холбогдох хуульд заасанчлан шийдвэрлэх шаардлагатай.

4.2 Сургалт, мэдээллээр хангах

Хорооны зохицуулалттай тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд нь Хорооноос тусгай зөвшөөрөл авсан цагаас эхлэх холбогдох хууль тогтоомж, Хорооноос гаргасан хэм хэмжээг дагаж мөрдөх үүргийг хүлээдэг. Зохицуулагч байгууллагын зүгээс хууль тогтоомжийг мөрдүүлэх, хяналт шалгалтын үр дүнтэй байдал нь тасралтгүй үргэлжлэх зайны болон газар дээрх хяналт шалгалт хийхтэй зэрэгцэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сургалт, мэдээллээр дамжуулан зохицуулалттай этгээдэд туслалцаа үзүүлэх нь өндөр ач холбогдолтой.

Сургалт, мэдээлэл, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ мэдээлэл хүргүүлэх олон талын сувгийг ашиглах бүрэн боломжтой бөгөөд тухайн этгээдийн үйл ажиллагааны төрөл, цар хүрээ, түвшин цаашлаад үйл ажиллагаа эрхэлж буй хэлбэр, байршил зэргийг харгалзана. Үүнд гарын авлага, тараах материал, танилцуулах хуудас зэрэг мэдээлэл түгээх олон төрлийг сувгийг хамруулна.

4.3 Зайны хяналт шалгалт

Хороо зайны болон газар дээрх хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлж ажиллана. Хороо байгууллага тус бүрийн эрсдэлийг үнэлж, сар, улирал бүр ирүүлсэн тайлан мэдээг хянаж, эрсдэлийг шинжилж, санхүү, төлбөрийн чадвар, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгнө. Ингэхдээ холбогдох бусад хүчин зүйлсийн эрсдэлийг салбарын ерөнхий эрсдэлийн үнэлгээ, гуравдагч мэдээллийн эх үүсвэрээс авсан мэдээ мэдээлэл, эрсдэлийн үнэлгээний асуулга, иргэд, олон нийтээс ирүүлсэн гомдол, холбогдох эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн мэдээ, мэдээлэл зэрэг хүчин зүйлсийг харгалзаж үзнэ. Зайны хяналтын үр дүнд шаардлагатай тохиолдолд санхүү, төлбөрийн чадварыг нь сайжруулах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгөх, газар дээрх хяналт шалгалтаар орох санал боловсруулах зэрэг эрсдэлийн түвшинтэй уялдуулсан арга хэмжээг авч ажиллана.

4.4 Газар дээрх хяналт шалгалт

Салбарын болон байгууллага тус бүрийн эрсдэлийн түвшингийн үр дүн болон зайны хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулна. Түүнчлэн системийн ач холбогдолтой байдал, удирдлага, засаглалд томоохон өөрчлөлт орсон эсэх зэрэг хүчин зүйлсийг авч үзнэ. Хяналт шалгалтыг хийхдээ эрсдэлд суурилсан аргачлал дээр тулгуурлан хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй байршуулах зорилгоор өндөр эрсдэлтэй байгууллагуудыг давтамж өндөртэйгөөр, харин бага эрсдэлтэй байгууллагуудыг давтамж багатайгаар газар дээрх хяналт шалгалтад хамруулахаар төлөвлөнө. Газар дээрх хяналт шалгалт эхлэхээс өмнө шалгалтын удирдамжийг батлуулж, шалгалтад хамрагдах байгууллагуудад мэдээлж, газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

Газар дээрх хяналт шалгалтаар алдаа дутагдал, зөрчил илэрсэн тохиолдолд түүний цар хүрээ, учруулж болох эрсдэл, аюул занал, холбогдох мэдээллийг тусгаж, түүнийг засаж, залруулах чиглэлээр авах арга хэмжээг мөн уг тайланд ойлгомжтой хэлбэрээр тусгасан байна. Шалгалтын дүгнэлтээс хамааруулж, шаардлагатай тохиолдолд тухайн байгууллагын эрсдэлийн үнэлгээнд өөрчлөлт оруулна.

4.5 Зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ

Хорооны хянан шалгагчид нь зайны болон газар дээрх хяналт шалгалтаар зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд тэдгээрийг арилгах, санхүүгийн салбарыг эрсдэлд оруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох арга хэмжээг авч ажиллана. Ингэхдээ хянан шалгагч нь аливаа алдаа, дутагдлыг эрт үе дээр илрүүлэх, түүнийг залруулах арга хэмжээ авна. Хянан шалгагч нь зөрчил, дутагдлыг залруулах чиглэлээр илэрсэн алдаа дутагдлын зэрэг, эрсдэлийн төвшнөөс хамааруулан тайлангийн хариу болон шалгалтын тайлангаар, түүнчлэн тухайн байгууллагын удирдлага, ТУЗ-д заавар зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар, Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлнэ. Эдгээрийн хэрэгжилтийг Хороо албан бичгээр хүлээн авах ба биелэлтийг тухай бүр тооцож ажиллана. Хорооны хянан шалгагчийг өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхээс татгалзсан, биелүүлээгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, үйл ажиллагаанд хязгаарлалт тавих, гүйцэтгэх захирлыг өөрчлөх санал гаргах, захиргааны шийтгэлийн арга хэмжээ авч ажиллах эрхтэй. Ингэхдээ Хорооны хянан шалгагч нь илэрсэн дутагдалд дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц арга хэмжээг авна. Хэрэв илэрсэн зөрчил гэмт хэргийн шинжтэй тохиолдолд хууль хяналтын холбогдох байгууллагад мэдээллийг хүргүүлж, хамтран ажиллана. Ийнхүү алдаа, дутагдлыг арилгах арга хэмжээ авах нь үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийг засаж, залруулахаас гадна зохицуулалттай байгууллагад хууль тогтоомжийг сахиж, мөрдөх соёлыг дэмжих ач холбогдолтой.

4.6 Гүйцэтгэлийн хяналт шалгалт

Зохицуулалттай байгууллагын илэрсэн алдаа, дутагдлыг залруулах чиглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Хорооны хянан шалгагч нэмэлт баримт бичиг, тайлбар шаардах, газар дээр очиж шалгах, үзлэг хийх, удирдлагуудтай уулзаж, ярилцах зэрэг гарсан ахиц, дэвшлийг шалгах, үр дүнг хэмжих, биелэлтийг хангуулах арга хэмжээг авч ажиллана. Ингэснээр байгууллагууд алдаа дутагдлыг залруулж, тухайн байгууллагад болон салбарын хэмжээнд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, хууль тогтоомжийн биелэлтийг сайжруулах, комплаенсын соёлыг бий болгож хэвшүүлэх, түүнийг дэмжих боломжийг бий болгоно. Хянан шалгагчид тухайн байгууллагын өмнө гаргасан зөрчил, дутагдал,

тэдгээрийг залруулах чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үүрэг даалгаврын биелэлт зэргийг байгууллагын эрсдэлийг үнэлэхдээ тооцож ажиллана.

Зураг 6. Хяналт шалгалтын үе шат



ТАВ. ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨРЛҮҮД

Хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан бүрэн эрхийн дагуу зохицуулалттай этгээд нь тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа байдал болон салбарын хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Зээлийн мэдээллийн сангийн тухай, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай, Компанийн тухай болон Иргэний хуулийг тус тус хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих эрх үүрэгтэй байна.

Хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ Хороо нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хуульд заасан үндэслэл журмын дагуу хийх бөгөөд зайны болон газар дээрх хэлбэрээр тасралтгүй хэрэгжүүлнэ.

Газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ Хорооны даргын тушаалаар баталсан удирдамжийн дагуу газар дээрх хяналт, шалгалт хийх бөгөөд удирдамжид шалгалтын зорилго, үндэслэл, төрөл, хэрхэн хяналт шалгалтыг явуулах талаар болон шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, объектын нэр, шалгалтын ажлын хэсгийн

бүрэлдэхүүн, тухайн шалгалт эхлэх болон дуусах хугацааны талаарх мэдээллийг багтаасан байдаг. Хяналт шалгалт эхлэхээс өмнө хянан шалгагч нь шалгуулах этгээдэд шалгалтын зорилго, бүрэлдэхүүн, удирдамжийг танилцуулах бөгөөд тухайн газар дээрх хяналт шалгалтыг удирдамжид заасан асуудлын хүрээнд хийж гүйцэтгэнэ. Шалгалтын явцад тодруулах шаардлагатай нэмэлт асуудал илэрсэн тохиолдолд удирдамжид тусгаагүй материалыг тухайн байгууллагаас гаргуулан авч болно.

Газар дээрх хяналт шалгалтыг хугацаа, шинж чанар, хийгдэж буй нөхцөл байдлаас хамаарч дараах байдлаар хуваана. Үүнд:

5.1 Эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалт

Зохицуулалттай этгээдийн буюу тухайн байгууллагын тухайн цаг үед болон ирээдүйд учирч болох эрсдэлийг тодорхойлж, эдгээр хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийсэн эрсдэлийн үнэлгээ, зайны хяналтын үр дүнд суурилж, шаардлагатай тохиолдолд газар дээрх хяналт шалгалтыг явуулдаг. Өөрөөр хэлбэл зохицуулагч байгууллагын зүгээс өөрийн зохицуулалттай этгээдүүдэд тодорхой хугацаанд бүгдэд нь газар дээрх хяналт шалгалт хийхээс илүүтэйгээр эрсдэлийг тодорхойлсны үндсэнд тухайн эрсдэлтэй этгээдэд газар дээрх хяналт шалгалт хийх нь өндөр ач холбогдолтой байдаг байна.

Эрсдэлд суурилсан газар дээр хяналт шалгалт нь тухайн зохицуулалттай этгээдийг үйл ажиллагаанд үүссэн, үүсэж болзошгүй эрсдэлд чиглэн газар дээрх хяналт шалгалтыг оновчтой, байлгахад зорьдог.

Тухайн зохицуулалттай этгээдийн эрсдэлийн үнэлгээ, зайны хяналтын үр дүнд үндэслэн эрсдэлийн зэргээс хамаарч газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөг гаргах бөгөөд Хорооны дарга буюу Улсын ерөнхий байцаагчаар батлуулна. Газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөнд шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулж болох ба уг төлөвлөгөөний дагуу хийгдэх газар дээрх хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалт гэж үзнэ.

Түүнчлэн тухайн зохицуулалттай этгээдэд гарсан үйл ажиллагааны болон бүтцийн огцом өөрчлөлт зэрэгт үндэслэн шаардлагатай тохиолдолд хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй этгээдэд газар дээрх хяналт шалгалтыг гүйцэтгэж болно. Энэ нь нэг талаас төлөвлөгөөт бус/ гэнэтийн газар дээрх хяналт шалгалт гэж харагдах хэдий ч эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалтын нэг хэлбэр юм.

Харин Хороонд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн гомдол, хүсэлт, холбогдох бусад эрх бүхий төрийн байгууллагаас ирүүлсэн мэдээлэл зэрэг нь тухайн этгээдийн эрсдэлийн үнэлгээ буюу эрсдэлийн мэдээллийн сан, зайны хяналтын дүгнэлтэд өөрчлөлт оруулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл дээрхийн дагуу газар дээрх хяналт шалгалтыг явуулна.

Эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалт нь бүхэлд нь буюу иж бүрэн шалгах аас гадна Зорилтот газар дээрх хяналт шалгалтыг явуулж болно.

Зорилтот газар дээрх хяналт шалгалт нь хяналт шалгалтаар тодорхойлогдсон эрсдэл /бүтээгдэхүүн үйлчилгээ, газар зүйн байршил, комплаенс г.м/ бүхий мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг гүйцэтгэхийг хэлнэ. Аливаа эрсдэл олон байгууллагын хүрээнд үүсэж болзошгүй байдаг. Иймд, хяналт шалгалтаар тухайн эрсдэлийн нөлөөлөлд гол анхаарлыг хандуулж ажиллана. Өмнөх шалгалтын үр дүн эсхүл чиг хандлагын үнэлгээ (trend analysis)-нд үндэслэн эрсдэлийн хүрээг сонгож болно (тухайлбал, ижил төстэй дутагдал илэрсэн байгууллагууд). Ялангуяа олон тооны мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалт хийх

шаардлагатай тохиолдолд, зорилтот хяналт шалгалтыг авч хэрэгжүүлснээр хянан шалгагчийн хязгаарлагдмал нөөц бололцоог оновчтой ашиглах юм.

5.2 Прудент буюу Зохистой байдлын хяналт шалгалт

Прудент хяналт шалгалтын зорилго нь зохицуулалттай байгууллагууд тогтвортой санхүүгийн үйл ажиллагаа явуулж, нийт санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад оршино.

Өөрөөр хэлбэл энэ төрлийн хяналт шалгалт нь тухайн зохицуулалттай этгээд хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааны зохистой түвшинд ажиллаж байгаа эсэхэд, тухайн байгууллагын аюулгүй, найдвартай байдал, салбарын тогтвортой байдлыг хангуулахад чиглэгдэх бөгөөд тусгай зөвшөөрөл авах үеэс эхлэн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа, засаглалын зохистой байдлыг хангуулах зорилготой ба цаашлаад байгууллагын эрх бүхий албан тушаалтан, гол хувьцаа эзэмшигч эрх бүхий этгээдийн тохиромжтой этгээд эсэхийг тодорхойлох тул зохицуулалттай этгээдийн засаглал, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны зохистой байдлын байнгын үнэлгээ гэж үзэж болно.

Прудент хяналт шалгалт нь зайны болон газар дээрх хэлбэрээр хийгдэхээс гадна микро болон макро түвшинд авч хэрэгжүүлж болно.

Микро түвшинд авч үзвэл, хуулийн этгээдүүд өөрийн эрсдэлийг бие даан хянах үүрэгтэй байдаг. Хянан шалгагч нар санхүүгийн системээс нийгэмд учруулж буй эрсдэлийг зохистой байдлын иж бүрэн шалгалт хийх үүрэгтэй. Макро-прудент хяналт шалгалт нь санхүүгийн бүрэлдэхүүн хэсгүүдэд бус нийт санхүүгийн системийн тогтвортой байдалд чиглэсэн хяналт юм.

Макро-прудент болон микро-прудент хяналт шалгалтыг хослуулснаар, тухайн салбарын эмзэг байдал болон эрсдэлийг эрт илрүүлэхийн сацуу зохих бодлогын арга хэмжээ авах замаар нийт салбарт учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлнэ. Эдийн засагт сөрөг нөлөө, үр дагаврыг авчрахаас сэргийлэх үүднээс макро-прудент хяналт шалгалтаар санхүүгийн байгууллагуудын хоорондын харилцаа хамааралд дүн шинжилгээ хийж санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангадаг. Макро-прудент хяналт шалгалт нь санхүүгийн зах зээлийн хөгжил, дэд бүтцээс үүсэх аливаа эрсдэлийг олж тогтоох мөн хянахад чиглэсэн бүх үйл ажиллагааг багтаана.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын санхүүгийн салбарт хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх аргачлалд, прудент хяналт шалгалт болон МУТСТ хяналт шалгалтыг нэг байгууллагаас 2 өөр баг эсхүл албанаас гүйцэтгэж байгаа тохиолдолд, эдгээр нэгжүүд МУТСТ хяналт болон комплаенсын асуудалд хоорондын уялдаа холбоог ханган ажиллах шаардлагатайг дурдсан. Тиймээс мэдээлэх үүрэгтэй этгээдэд прудент хяналт шалгалтыг гүйцэтгэхэд, МУТСТ чиглэлийн хяналт шалгалтыг зэрэг хэрэгжүүлж нийт хяналт шалгалтын процессын уялдаа холбоог хангаж ажиллах нь зүйтэй.

Энэ төрлийн хяналт шалгалтыг хэсэгчилсэн, үзлэг хэлбэрээр явуулах боломжтой бөгөөд дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

а) Хэсэгчилсэн

Хороо нь иргэд, хуулийн этгээд, төрийн эрх бүхий байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр гарсан шүүмжлэл, баримтын мөрөөр эсхүл Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн аль нэг хэсэг, зохицуулалттай этгээдийн дотоод үйл ажиллагааны аль нэг хэсгийг асуудлын нэр төрлөөр нь шалгаж үнэлэлт, дүгнэлт өгч болно. Энэ төрлийн газар дээрх хяналт шалгалтыг хэсэгчилсэн гэж үзнэ.

b) Үзлэг

Хянан шалгагч нь зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаатай газар дээр нь танилцах зорилгоор богино хугацаанд ерөнхий үзлэгийг зохион байгуулж болно. Газар дээрх үзлэг нь тухайн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны зохистой байдал, зохицуулалттай этгээдүүдийн үйл ажиллагааны түвшин, газар зүйн байршил зэргээс харгалзан зохион байгуулагдана.

Хянан шалгагч нь үзлэг хийх явцад хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл нь илэрсэн бол холбогдох хууль журам, Хорооны Улсын байцаагчийн дүрэмд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэхээс гадна газар дээрх хяналт шалгалтыг явуулах санал гаргаж болно.



Санамж: Прудент хяналт шалгалт болон мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрх хяналт шалгалтын уялдаа холбоо

Хорооны тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд нь ФАТФ-ын зөвлөмж, аргачлал, Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг тус тус хангуулах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй.

Хороо нь зохицуулалттай этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, дотоод хяналтын тогтолцоонд үнэлэлт, дүгнэлт өгч, зайны болон газар дээрх хяналт шалгалтыг тасралтгүй явуулдаг ба энэ талаараа мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт шалгалт нь прудент буюу зохистой байдлын хяналт шалгалтаас ялгагддаг байна.

Прудент хяналт шалгалт болон мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрх хяналт шалгалт нь холбогдох хууль тогтоомж, олон улсын стандарт шаардлагад заасанчлан харилцан уялдаатай явагддаг бөгөөд хэрхэн хэрэгжүүлэхийг зохицуулагч байгууллага дотоод зохион байгуулалт, хүний нөөцийн чадамжаас хамаарч тохиромжтой байдлаар зохион байгуулдаг. Зохицуулагч байгууллагын бүтэц зохион байгуулалт ямар байхаас үл хамааран дээрх 2 төрлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ мэдээллийн урсгалын уялдаа холбоог тасралтгүй байхад анхаарах шаардлагатай ба энэ нь хяналт шалгалтын үр дүнтэй байдлыг нэмэгдүүлдэг болно.

Газар дээрх хяналт шалгалт нь эрсдэлд суурилсан эсхүл Прудент буюу Зохистой байдлын хяналт шалгалтыг эсэхээс үл хамааран тухайн газар дээрх хяналт шалгалт нь хамтарсан болон нэгдсэн байдлаар явуулж болно.

Хороо нь бусад төрийн байгууллагын төлөөллийг оролцуулан нэгдсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр хамтарсан газар дээрх хяналт шалгалтыг явуулж болно. Хамтарсан газар дээрх хяналт шалгалт нь холбогдох хууль тогтоомжид заасан холбоотой заалттай харшлахгүй байхаас гадна хамтарч буй эрх бүхий байгууллагуудын удирдлагын тушаалаар баталгаажна.

Мөн санхүүгийн нэгдэл компаниудад нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, нэгдлийн хэмжээнд эрсдэлийг үнэлэх, үйл ажиллагаанд хяналт тавина. Санхүүгийн нэгдлийн хэмжээнд шаардлагатай гэж үзвэл Монголбанк, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нэгдсэн хяналт шалгалтыг хийж болно.



БҮЛЭГ 2.

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ
БОЛГОХ ДУНД БОЛОН УРТ ХУГАЦААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 2-ЫН АГУУЛГА

НЭГ. ХОРООНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, ЦААШДЫН ХАНДЛАГА.....6..	22
1.1.Хяналт шалгалтын өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ	22
1.2.Хяналт шалгалтын цаашдын бодлого	24
ХОЁР. ХОРООНЫ ХЯНАЛТЫН ШАЛГАЛТЫН БОДЛОГО	
2.1. Хяналт шалгалтын бодлого	25
2.2. Бодлогын зорилго	25
2.3. Бодлогын зорилгод хүрэх зорилтууд	27
2.4. Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	27
2.5. Бодлогын суурь түвшин, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт	35

НЭГ. ХОРООНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, ЦААШДЫН ХАНДЛАГА

1.1. Хяналт шалгалтын өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ

Хорооны хяналт шалгалтын өнөөгийн нөхцөл байдалд давуу тал, сул тал, хөгжлийн боломж, аюул эрсдэлийг тодорхойлоход дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Нөхцөл байдлын шинжилгээ

Давуу тал	Боломж
<p>-Хороо санхүүгийн салбарт 16 жил хяналт шалгалт хийсэн туршлагатай, зохицуулалт хариуцсан тусдаа газар нэгжтэй болно.</p> <p>-Зохицуулалттай 6 салбарт зайны болон газар дээрх хяналт шалгалтыг явуулж байна.</p> <p>-Зохицуулалттай этгээдийн санхүүгийн тайлан, мэдээг хүлээн авч хянах Фина системийг хөгжүүлэн ашиглаж, зохицуулалттай этгээдийн сар, улирал тутмын санхүүгийн тайлан, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг цахимаар хүлээн авч, зайны хяналт хийж байна.</p> <p>-Цахимаар тайлан, мэдээ хүлээн авч, хянах үйл ажиллагаа болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоосон бие даасан журамтай ба тус журмыг хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөж ажилладаг.</p> <p>-Хянан шалгагч нарын талаас илүү хувь олон жил ажилласан туршлагатай.</p> <p>-Тасралтгүй хяналт шалгалтын үр дүнд илэрсэн зөрчилд холбогдох мэдэгдэл, тайлангийн хариу, УБАШ, Захиргааны хариуцлагын арга хэмжээ авч, эдгээр үүрэг даалгаврын хэрэгжилтэд мөн хяналт тавьдаг.</p> <p>-Зохицуулалттай этгээдэд хийх газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөг жил бүр гаргаж, газар дээрх үзлэг, шалгалтыг гүйцэтгэдэг.</p> <p>-Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх чиг үүрэгтэй албыг байгуулж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулиудын хэрэгжилтийг мэдээлэх үүрэгтэй этгээдэд хангуулах, хяналт тавих ажлыг гүйцэтгэж байна.</p>	<p>-Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг бүрэн нэвтрүүлснээр, нөөцийг оновчтой хуваарилж, хяналт шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийн оролцогчдын эрсдэлийг тооцох, удирдах тогтолцоо бүрдэх;</p> <p>-Зохицуулалттай этгээдэд учирч болзошгүй эрсдэлд урьдчилж арга хэмжээ авснаар цаашдын хохирлоос сэргийлэх;</p> <p>-Албан хаагчдын ур чадварыг дээшлүүлж, хяналт шалгалтын шинэлэг арга хэлбэрийг нэвтрүүлснээр нэг ажилтанд ногдох ачаалал буурах, ажлын үр бүтээмж сайжрах;</p> <p>-Газар нэгжүүдийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулснаар мэдээллийн зөрүүтэй байдал үүсэхээс сэргийлэх, хяналтын үр дүн нэмэгдэх;</p> <p>-Зохицуулалттай этгээдэд зориулсан сургалтыг оновчтой зохион байгуулж, мэдээ мэдээллээр тогтмол хангаснаар тэдгээрийн санхүүгийн тайлагнал, үйл ажиллагааны чанар сайжирч, цаашлаад эрсдэл буурах;</p> <p>-Аливаа үйл ажиллагаа, материалын архивыг цахимжуулснаар хяналт шалгалтын үйл ажиллагаа дах мэдээллийн саад арилах, цаг хугацаа хэмнэх болон цаасан материал алдагдах, үрэгдэхээс сэргийлэх;</p> <p>-Хяналт шалгалтын үнэлгээний асуулгыг чиглэл бүрээр баталснаар зайны хяналтыг үр дүнтэй болгох;</p> <p>-Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах ажлын хүрээнд, зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаатай холбоотой санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх тусгайлсан чиг үүрэг бүхий нэгж ажилладаг тул өргөдөл гомдлын дагуу тухайн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих.</p>

Сул тал	Эрсдэл
<p>-Хяналт шалгалтын газрын хүний нөөц хангалтгүй, ачаалал өндөртэй байдаг.</p> <p>-Хяналт шалгалтын хүрээнд эрсдэлд суурилсан хяналтыг бүрэн нэвтрүүлээгүй ба эрсдэлийн үнэлгээг хийх нарийвчилсан заавар, тогтолцоог хөгжүүлээгүй тул хяналт шалгалтын үйл ажиллагаанд цаг хугацаа, хүн хүч их шаардагддаг.</p> <p>-Олон улсын шинэ арга, туршлагыг нэвтрүүлэх тал дээр албан хаагчдыг сургах, ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай.</p> <p>-Цахим тайлан хүлээн авах системд одоог хүртэл зарим алдаа, дутагдал байгаагаас тайлангийн хяналтыг гүйцэтгэхэд гар ажиллагаа шаардагдаж, цаг хугацаа их алддаг.</p> <p>-Зохицуулалттай этгээдийн хувийн хэрэг, материалын бүрдүүлэлтийн цахим архив байхгүй тул өмнөх онуудын материалыг давхар хянах боломжгүй. Өмнөх хугацааны материалуудыг үзэхийн тулд заавал цаасан архивыг шалгах шаардлага үүсдэг нь цаг хугацаа, хүртээмжтэй байдлын хувьд хүндрэл үүсгэдэг.</p> <p>-Хууль эрх зүйн орчны уялдаагүй байдал нь дүрэм журмын хэрэгжилтийг хангах үйл явцыг төвөгтэй болгодог.</p> <p>-Байгууллагын бизнес төлөвлөгөөний хэрэгжилтэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийгддэггүй.</p> <p>-Зөрчлийн мэдээллийн нэгдсэн сан байхгүй.</p> <p>-Хянан шалгагч дэвшилтэд технологид суурилсан санхүүгийн программ хангамжид хяналт тавихад мэргэшээгүй.</p> <p>-Хяналт шалгалт, зөрчлийн мэдээлэл ил тод байлгах зохицуулалт байхгүй.</p>	<p>-Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо бүрэн нэвтрээгүйн улмаас хяналт шалгалтын үр дүн буурах, цаашлаад зохицуулалттай этгээдийн тоо, чиглэл нэмэгдэх тусам албан хаагчдын ачаалал нэмэгдэх.</p> <p>-Шинэлэг мэдээлэл, олон улсын болон зах зээлийн мэдлэг, туршлагаар албан хаагчдыг хангаагүйгээс аливаа шинэ үйл ажиллагаа, гэнэтийн өөрчлөлтөд бэлэн бус байх.</p> <p>-Хяналт шалгалт, зөрчлийн цахим мэдээллийн нэгдсэн сангүй тул шаардлагатай мэдээлэл цаасан хэлбэрээр алдагдах, үрэгдэх.</p> <p>-Бизнес төлөвлөгөө, түүний гүйцэтгэлд хяналт шалгалт хийхгүйн улмаас зохицуулалттай этгээд төлөвлөлтгүй үйл ажиллагаа эрхэлж өндөр эрсдэлд орох.</p> <p>-Цахим болон крипто санхүүгийн хэрэгсэл, урамшууллын оноог зах зээлд ихээр сурталчилж, энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэд ихээр авч байгаа боловч энэ төрлийн санхүүгийн хэрэгслийн зохицуулалт, хяналт байхгүй байгаа нь таамаглаагүй эрсдэл дагуулах аюултай.</p> <p>-Хяналт шалгалтын нэгдсэн нэг ойлголт, бодлогын баримт бичиг байхгүйн улмаас ойлголтын зөрүүтэй байдал бий болох.</p> <p>-Санхүүгийн зах зээлд оролцогчдын санхүүгийн мэдлэг дутмаг байдлаас болж эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийх.</p> <p>-Олон нийт, зохицуулагч байгууллагуудаас Хорооны үйл ажиллагаа, шийдвэрийг хүндэтгэхгүй байх, итгэл буурах.</p>

Хорооны зохицуулалттай салбаруудын зах зээлийн онцлог, оролцогчдын тоо хэмжээ, ирээдүйд тулгарах эрсдэлүүд өдөр өдрөөр хувьсан өөрчлөгдөж, улам нэмэгдэх чиг хандлагатай байгаа тул үүнд хяналт тавьж буй албан хаагчдын хязгаарлагдмал нөөц бололцоог үр дүнтэй хуваарилах, цаашлаад шинээр нэмэгдэх зохицуулалттай салбарын үндсэн суурийг бий болгох, хяналтын бодлогыг зөв тодорхойлох, ухаалаг үр дүнтэй дэвшилтэд технологид суурилсан (technology based) зохицуулалтын орчныг бий болгох зэрэг шаардлага үүсээд байна.

Үүний дагуу авч хэрэгжүүлбэл зохих эхний арга хэмжээ нь “Хяналт шалгалтын бодлогыг баримт бичиг” байх бөгөөд тус баримт бичгийг бүхий л үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, үүсэж буй нөхцөлд байдалд нийцүүлэн шинэчлэх зэргээр ашиглах боломжтой юм.

1.2. Хяналт шалгалтын цаашдын бодлого

Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал дэлхий дахинд эрчтэй өрнөж буй энэ үед ухаалаг ажиллагаа, амар хялбар байдлаар үйлчилгээ хүргэх нөхцөлийг бүхий л салбарт хэрэгжүүлж, шинэчлэл хийх шаардлага үүсэж байна. Санхүүгийн болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарт мөн адил шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд хиймэл оюун ухаан, дэвшилтэд технологид суурилах хэрэгцээ шаардлага бий болсон тул хэрэглэгч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, салбарын тогтвортой өсөлт хөгжлийг хангах, олон улсын зохицуулалтын шинэ арга хэлбэрийг судлах, нэвтрүүлэх салбарын бодлого зохицуулалтын орчин бий болгох шаардлага үүсээд байна.

Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 4.3-д “Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон, олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ” гэж заасны дагуу (1) эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, дижитал технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх, (2) томоохон хөрөнгийн биржүүдэд хамтран дотоодын санхүүгийн хэрэгслийг чөлөөтэй арилжаалах, мэргэжлийн тоглогчдын оролцоо, хөрөнгө оруулалт татах боломж бүрдүүлэх, дэлхийн хөрөнгийн зах зээлд оролцох түвшний дижитал санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх, (3) санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилан дэлхийн түвшинд хөгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий чиглэлийг баталсан байна.

Олон улсын санхүүгийн зах зээлд гарч буй өөрчлөлт болон Монголын Улсын эдийн засагт баримталж буй бодлоготой нийцүүлэн Хорооны өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ, түүнээс урган гарах нөөц боломж, хүндрэл бэрхшээлд тулгуурлан Хорооны хяналт шалгалтын бодлого нь дараах асуудлуудыг эн тэргүүнд тусгаж, шийдвэрлэх нь чухал байна. Үүнд:

- Хорооны зүгээс эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зохицуулалтыг чанаржуулж, зохицуулалтын бүх салбарт хэрэгжүүлэх, санхүүгийн салбарын мэргэжлийн оролцогчдын тогтвортой үйл ажиллагааг дэмжих чиг үүргийнхээ хүрээнд дэлхий дахинд гарч буй зах зээлийн хөгжлийг дэмжихүйц зохицуулалтын арга хэрэгслийг судлах, түүнийг хяналт шалгалтад нэвтрүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх;
- Бизнес, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж эхэлсэнтэй холбогдуулан тэдгээрийн найдвартай ажиллагаа, өргөжилтийг дэмжсэн, хэрэглэгчийн эрх ашиг хамгаалагдсан, мэдээллийн аюулгүй байдал хангагдсан зохицуулалтын орчныг бий болгох, хөгжүүлэх, түүнд хүрэх шийдэл гарцаа тодорхойлсон байх учиртай тул технологид суурилсан хяналт шалгалт (supervisory technology) болон технологид суурилсан зохицуулалт (regulation technology) буюу санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэлийн үнэлгээний технологид суурилсан хяналт шалгалтыг бий болгох;
- Уламжлалт санхүү хийгээд технологийн хөгжлийг хослуулсан финтек, блокчейн, их хэмжээний өгөгдөл, хиймэл оюун ухаан, үүлэн тооцоолол зэрэг сүүлийн үеийн технологи илүү боловсронгуй хэлбэрт шилжин, хөгжиж буй улс орнууд энэхүү технологиудыг туршин эрчимтэй ашиглаж байна. Энэхүү санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгаалсан үр ашигтай, зохистой зохицуулалтаар удирдан чиглүүлэх, хөгжүүлэхэд хяналт тавих хянан шалгагч нарыг бэлтгэх, чадавхжуулах;
- Эдийн засгийн гэмт хэрэг, санхүүгийн зөрчил гарсны дараа хариуцлага тооцох механизмыг сайжруулахаас илүүтэй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн

удирдлагыг зөв залуурдан жолоодох, хууль бус үйлдлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, мэдээлэлтэй санхүүгийн зах зээлд оролцогчдыг бэлтгэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг дэмжих;

- Хяналт шалгалт, зөрчлийн талаарх мэдээллийн ил тод байдлыг хангаж шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Санхүүгийн зах зээл оролцогчид буюу хэрэглэгчийн эрх хамгаалахад чиглэсэн тогтолцоо бий болгох шаардлагууд зайлшгүй урган гарч байна.

ХОЁР. ХОРООНЫ ХЯНАЛТЫН ШАЛГАЛТЫН БОДЛОГО

2.1. Хяналт шалгалтын бодлого

Аливаа улс орны санхүүгийн салбарын зохицуулагч төрийн эрх бүхий байгууллагын үндсэн суурь үйл ажиллагаа нь санхүүгийн болон санхүүгийн бус зах зээлийн оролцогчдын “тоглоомын дүрмийг” тодорхойлох буюу тухайн салбарт дагаж мөрдөх хууль, эрх зүйн орчныг зохицуулагч болон зохицуулалттай этгээдийн эрх үүргийг тусган хамтран бүрдүүлэх, үүний хэрэгжилтэд хяналт тавих, болон тухайн салбараар үйлчлүүлэгч иргэдийн эрх ашгийг хамгаалахад оршино.

Хорооны хяналт шалгалтын бодлогоор дамжуулж чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэх болно.

2.2. Бодлогын зорилго

Хорооны хяналт шалгалтын бодлого нь(1) эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг чанаржуулж санхүүгийн тогтвортой байдлыг хангана, (2) хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг бэхжүүлэх, (3) уламжлалт болон технологид суурилсан (supotech) хяналт шалгалтын хосолсон үр ашигтай, оновчтой тогтолцоог бий болгоно, (4) соён гэгээрүүлэх-гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгоно, (5)ёс зүй, цогц чадамжтай хянан шалгагчийг бэлтгэж хяналт шалгалтын чанарыг, үр ашгийг дээшлүүлнэ, (6)хяналт шалгалтын мэдээллийн ил тод байдлыг хангаж шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлнэ гэсэн зургаан зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

2.3. Бодлогын зорилгод хүрэх зорилтууд

Бодлогын суурь зургаан зорилгод хүрэх зорилтууд дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Бодлогын зорилго, зорилт

Зорилго 1	Зорилго 2	Зорилго 3
Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг чанаржуулж, эргэх холбоо (feedback)-г сайжруул-на.	Уламжлалт болон технологид суурилсан(supotech) хяналт шалгалтын хосолсон үр ашигтай, оновчтой тогтолцоог бий болгоно.	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг бэхжүүлнэ.

Зорилт	Зорилт	Зорилт
<p>1.1. Үнэн зөв, бодит мэдээллийг шуурхай солилцох тогтолцоог бүрдүүлэх</p> <p>1.2. Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, эргэх холбоог сайжруулах</p> <p>1.3. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үр ашгийг нэмэгдүүлэх</p>	<p>2.1. Дэвшилтэд технологи ашиглан хяналт шалгалт хийх бэлтгэл хангах</p> <p>2.2. Өгөгдөл (data) нийлүүлэгч байгууллагуудыг технологид суурилсан хяналт шалгалтад бэлтгэх</p> <p>2.3. Технологид суурилсан хяналт шалгалтад шаардлагатай өгөгдлийн бааз бий болгох</p> <p>2.4. Өгөгдөлд дүн шинжилгээ хийж хяналт тавих аргачлал боловсруулах</p>	<p>3.1. Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах</p> <p>3.2. Хэрэглэгчийг хууран мэхлэлтээс хамгаалах</p> <p>3.3. Хэрэглэгчийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх хялбар механизмыг бий болгох</p> <p>3.4. Хэрэглэгчийн эрх ашгийг дэвшилтэд технологи ашиглаж хамгаалах</p> <p>3.5. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах</p>

Зорилго 4	Зорилго 5	Зорилго 6
<p>Соён гэгээрүүлэх-гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгоно.</p>	<p>Ёс зүй, цогц чадамжтай хянан шалгагчийг бэлтгэж хяналт шалгалтын чанар, үр ашгийг дээшлүүлнэ.</p>	<p>Хяналт шалгалтын мэдээллийн ил тод байдлыг хангаж шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлнэ.</p>

Зорилт	Зорилт	Зорилт
<p>4.1. Санхүүгийн боловсролыг нэмэгдүүлнэ</p> <p>4.2. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх</p> <p>4.3. Хууль, тогтоомжийн хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>5.1. Ёс зүй, цогц чадамжтай хянан шалгагчийг бэлтгэх суурь тогтолцоо бий болгох</p> <p>5.2. Хянан шалгагчийн сонгон шалгаруулалтыг бий болгох</p> <p>5.3. Өндөр ур чадвартай, чадварлаг, туршлагатай хянан шалгагчийг татах, хадгалах нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>6.1. Хорооны хяналт шалгалт, зөрчлийн цахим нэгдсэн санг бий болгох</p> <p>6.2. Хорооны хяналт шалгалтын үр дүнд бий болсон шийдвэрийг ил тод болгох</p> <p>6.3. Шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болох судалгаа хийх болгох</p>

2.4. Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хороо хяналт шалгалтын бодлогын зорилтыг хэрэгжүүлэхдээ дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.

Зорилго 1. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг чанаржуулж, эргэх холбоо (feedback)-г сайжруулна.

Хүснэгт 3. Зорилго 1-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа

Зорилт 1.1	Зорилт 1.2	Зорилт 1.3
Үнэн зөв, бодит мэдээллийг шуурхай солилцох тогтолцоог бүрдүүлэх	Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, эргэх холбоог сайжруулах	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үр ашгийг нэмэгдүүлэх
Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа
-Үнэн зөв, бодит мэдээллийг цаг алдалгүй нэгдсэн аргачлалаар цуглуулах механизм бий болгох -Мэдээллийн үнэн зөвийг нягтлах, эрсдэлийг илрүүлэх аргачлал боловсруулах -Мэдээллийн менежментийг сайжруулах	-Харьцуулсан судалгаа хийх -Эрсдэлийн үнэлгээний аргачлалыг сайжруулах -Олон улсын стандарт, заавар зөвлөмжийг нэвтрүүлэх -Илрүүлсэн эрсдэлийг баримтжуулах, бууруулах, арилгуулах арга хэмжээ авах, эргэх холбоог сайжруулах	-Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авах арга хэмжээний талаар хянан шалгагчид зориулсан заавар зөвлөмж боловсруулах -Эрсдэл гарах магадлал, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар зохицуулалтыг бий болгох

Зорилт 1.1. Үнэн зөв, бодит мэдээллийг шуурхай солилцох тогтолцоог бүрдүүлэх;

Үнэн зөв, бодит мэдээллийг цаг алдалгүй нэгдсэн аргачлалаар цуглуулах механизм бий болгох, мэдээллийн үнэн зөвийг нягтлах, эрсдэлийг илрүүлэх аргачлал боловсруулах, мэдээллийн менежментийг сайжруулах.

Зорилт 1.2. Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, эргэх холбоог сайжруулах;

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтад тулгарч буй болон болзошгүй хүндрэлийг илрүүлэх, стресс тест хийх аргачлалыг боловсруулах, эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, үнэлэх, шийдвэрлэх, хяналт хийхэд чиглэсэн аргачлалын сайжруулах, олон улсын стандарт, заавар зөвлөмжийг цаг хугацаанд нь нэвтрүүлэх.

Зорилт 1.3. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үр ашгийг нэмэгдүүлэх;

Эрсдэлийг тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар хянан шалгагчид зориулсан заавар зөвлөмжийг боловсруулах, эрсдэлээс үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар зохицуулалтыг бий болгох.

Зорилго 2. Уламжлалт болон технологид суурилсан /suptech/ хяналт шалгалтын хосолсон үр ашигтай, оновчтой тогтолцоог бий болгоно.

Хүснэгт 4. Зорилго 2-ын хүрээнд хийгдэх үйл ажиллагаа

Зорилт 2.1	Зорилт 2.2	Зорилт 2.3
Дэвшилтэд технологи ашиглан хяналт шалгалт хийх бэлтгэл хангах	Өгөгдөл нийлүүлэгч байгууллагуудыг технологид суурилсан хяналт шалгалтад бэлтгэх	Технологид суурилсан хяналт шалгалтад шаардлагатай өгөгдлийн бааз бий болгох
Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа
-Технологи ашиглан хяналт шалгалт хийх боломжит хяналт шалгалтыг тодорхойлох -Шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжийг хөгжүүлэх -Дэвшилтэд технологид суурилсан хяналт шалгалт хийх зохицуулалтын дүрэм, журам боловсруулах	-Хяналт шалгалтыг гүйцэтгэх технологи /suptec/, зохицуулалтын технологи /regtech/-ийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх -Байгууллагуудыг үйл ажиллагааг дижитал хэлбэрт шилжүүлэх, дэмжих -Мэдээлэл нийлүүлэх үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг бий болгох -Технологид итгэх итгэлийг нэмэгдүүлэх	-Өгөгдөл, мэдээллийн стандартыг бий болгох -Мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрсдэлийн удирдлагыг бий болгох -Өгөгдөл хадгалах байгууламжийг бий болгох, -Программууд хооронд өгөгдөл солилцох холбогдох зохицуулалтыг бий болгох;

Зорилт 2.4

Өгөгдөлд дүн шинжилгээ хийж хяналт тавих аргачлал боловсруулах

Үйл ажиллагаа

- Өгөгдөл судлаачид, хөгжүүлэгчдийг бэлтгэх
- Өгөгдөлд дүн шинжилгээ хийж хяналт тавих аргачлал гарын авлага боловсруулах
- Хиймэл оюун ухаан ашиглан стресс тест хийх, зохистой /prudential/ хяналт шалгалт болон эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх
- Холбогдох зохицуулалтын дүрэм, журам, гарын авлага боловсруулах

Зорилт 2.1.Дэвшилтэд технологи ашиглан хяналт шалгалт хийх бэлтгэл хангах

Технологи ашиглан хяналт шалгалт хийх эрсдэл, хязгаарлалтыг үнэлж боломжит хяналт шалгалтыг тодорхойлох, хянан шалгагчийн хийх боломжгүй хяналт шалгалтыг тодорхойлох, хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулдаг хяналт шалгалтыг тодорхойлох,шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжийг хөгжүүлэх, хяналт шалгалт гүйцэтгэх технологи /suptec/, зохицуулалтын технологи /regtech/-ийн хосолмол байдлаар хөгжүүлэх, холбогдох зохицуулалтын дүрэм, журам боловсруулах.

Зорилт 2.2. Өгөгдөл нийлүүлэгч байгууллагуудыг технологид суурилсан хяналт шалгалтад бэлтгэх

Хяналт шалгалтыг гүйцэтгэх технологи /suptech/, зохицуулалтын технологи /regtech/-ийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, боловсролыг нэмэгдүүлэх,санхүүгийн зах зээлд оролцогч байгууллагуудыг үйл ажиллагааг дижитал хэлбэрт шилжүүлэх, Хорооны тогтоосон мэдээллийн

стандартын дагуу өгөгдөл, мэдээллийг бэлтгэж нийлүүлэхтэй холбогдох дүрэм журам, стандартыг боловсруулах, технологид итгэх итгэлийг дэмжихийн тулд кибер аюулгүй байдлын асуудлыг чухалчлах.

Зорилт 2.3.Технологид суурилсан хяналт шалгалтад шаардлагатай өгөгдлийн бааз бий болгох

Өгөгдөл, мэдээллийн стандартыг бий болгох, мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрсдэлийн удирдлагыг бий болгох, өгөгдлийн бааз хадгалах байгууламжийг бий болгох, программ хангамжийн программууд хоорондоо өгөгдөл солилцох программыг ашиглах, холбогдох зохицуулалтын дүрэм, журам, гарын авлага боловсруулах;

Зорилт 2.4.Өгөгдөлд дүн шинжилгээ хийж хяналт тавих аргачлал боловсруулах

Өгөгдөл судлаачид, хөгжүүлэгчдийг бэлтгэх, өгөгдөлд дүн шинжилгээ хийж хяналт шалгалт хийх аргачлал, гарын авлага боловсруулах, хиймэл оюун ухаан болон хүний оролцоогүйгээр өгөгдөл боловсруулж, стресс тест хийх, зохистой /prudential/ хяналт шалгалт, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх шинжилгээний программыг хөгжүүлэх, холбогдох зохицуулалтын дүрэм, журам, гарын авлага боловсруулах.

Зорилго 3. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг бэхжүүлнэ.

Хүснэгт 5. Зорилго 3-ын хүрээнд хийгдэх үйл ажиллагаа

Зорилт 3.1	Зорилт 3.2	Зорилт 3.3
Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах	Хэрэглэгчийг залилан мэхлэх шинж чанартай гэмт хэргээс хамгаалах	Хэрэглэгчийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх хялбар механизмыг бий болгох
Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа
<ul style="list-style-type: none"> -Зохицуулалттай этгээдүүдийн мэдээллийн ил тод байдалд хяналт тавих -Хэрэглэгчдэд мэдээллийг бүрэн, шуурхай, үнэн зөв, ойлгомжтой мэдээлсэн эсэхэд хяналт тавих -Төрийн байгууллагууд болон салбарын холбоодтой хамтран ажиллах 	<ul style="list-style-type: none"> -Хэрэглэгчийн эрх ашигт хохирол учруулж болзошгүй этгээдийн бүртгэлийг бий болгох, -Олон нийтэд мэдээллийг ил болгох арга хэмжээ авах -Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хууль, тогтоом-жийг сурталчлах 	<ul style="list-style-type: none"> -Хэрэглэгчийн өргөдөл, гомдлыг шударга, үр ашигтай, хямд төсөр, түргэн шуурхай шийдвэрлэх хувилбарыг бий болгох
Зорилт 3.4	Зорилт 3.5	
Хэрэглэгчийн эрх ашгийг дэвшилтэд технологи ашиглаж хамгаалах	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах	

Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа
<p>-Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах виртуал программууд, дижитал хэрэгслүүдийг нэвтрүүлэх</p> <p>-Хэрэглэгчдийн зан байдлыг ойлгох зорилгоор холбогдох өгөгдлийг цуглуулах, хадгалах, дүн шинжилгээ хийх систем, процессыг бий болгох</p>	<p>- Дижитал санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтын зохицуулалтыг бий болгох,</p> <p>-Хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид тавигдах олон улсын стандартуудыг нэвтрүүлэх</p> <p>- Олон улсын стандарт тогтоогч байгууллагуудтай хамтран ажиллах.</p>

Зорилт 3.1. Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах:

Зохицуулалттай этгээдүүдийн мэдээллийн ил тод байдалд хяналт тавих, хэрэглэгчдэд мэдээллийг бүрэн, шуурхай, үнэн зөв мэдээлсэнд хяналт тавих, хэрэглэгчдэд мөнгөний менежмент, санхүүгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын ур чадварыг эзэмшүүлэхэд туслах зорилгоор бусад төрийн байгууллагууд болон салбарын холбоодтой хамтран ажиллах;

Зорилт 3.2. Хэрэглэгчийг хууран мэхлэх шинж чанартай гэмт хэргээс хамгаалах:

Зах зээлийн тогтвортой байдал, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашигт хохирол учруулж болзошгүй этгээдийн талаарх мэдээллийн бүртгэлийг бий болгох, олон нийтэд мэдээллийг ил болгох арга хэмжээ авах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг сурталчлах.

Зорилт 3.3. Хэрэглэгчийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх хялбар механизмыг бий болгох:

Хэрэглэгчийн өргөдөл, гомдлыг шударга, үр ашигтай, хямд төсөр, түргэн шуурхай шийдвэрлэх хувилбарыг бий болгох.

Зорилт 3.4. Хэрэглэгчийн эрх ашгийг дэвшилтэд технологи ашиглаж хамгаалах:

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах виртуал программууд, дижитал хэрэгслүүдийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хэрэглэгчдийн зан байдлыг ойлгох зорилгоор холбогдох өгөгдлийг цуглуулах, хадгалах, дүн шинжилгээ хийх систем, процессыг бий болгох.

Зорилт 3.5. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах:

Санхүүгийн хэрэглэгч, хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтын зохицуулалтыг бий болгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид тавигдах олон улсын стандартуудыг нэвтрүүлэх, дижитал санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон хууль эрх зүй, зохицуулалт, хяналтын тогтолцоог бий болгох, дижитал сувгаар дамжуулж хил дамнасан гүйлгээг хийдэг болсноор хил дамнасан тодорхой эрсдэлүүд үүсэж болзошгүй тул үйлдлийг таслан зогсоох, хохирлоо барагдуулах эсвэл албадан гүйцэтгэх арга хэмжээ авах чадамжийг бий болгохоор санхүүгийн салбарт олон улсын стандарт тогтоогч байгууллагуудтай хамтран ажиллах.

Зорилго 4. Соён гэгээрүүлэх-гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгоно.

Хүснэгт 6. Зорилго 4-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа

Зорилт 4.1	Зорилт 4.2
Санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх
Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа
<ul style="list-style-type: none">- Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зан үйл, дадлын талаар олон нийтэд тогтмол мэдээлэх, мэдэгдэл, зөвлөмж өгөх- Гэмт хэрэг, зөрчилд өртөх эрсдэлийн талаар таниулах, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, үйлдэгдэхээс өөрийгөө болон бусдыг хамгаалах зан суртахуун, дадал, чадварыг бий болгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах	<ul style="list-style-type: none">- Өөрийн үйл ажиллагааны онцлог, зан үйл, дадлаас хамааран гэмт хэрэг, зөрчилд өртөх, түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болзошгүй хүн, хуулийн этгээдийн хүрээг тодорхойлох аргачлал боловсруулах- Гэмт хэрэг, зөрчлийг өдөөж болзошгүй шалтгаан, нөхцөлийг тогтоож, тэдгээрийг саармагжуулах, арилгах арга хэмжээг авах зохицуулалтыг бий болгох
Зорилт 4.3	
Хууль, тогтоомжийн хүртээмжийг нэмэгдүүлэх	
Үйл ажиллагаа	
<ul style="list-style-type: none">- Гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх- Гэмт хэрэг, зөрчлийн нийгмийн хор аюулыг олон нийтэд таниулах ажлыг тасралтгүй явуулах- Гэмт хэрэг, зөрчлийг хянан шалгах болон түүнд хяналт тавих үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах- Гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх, хохирол, хор уршгийг нөхөн төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх- Шударга ёсны тогтолцоонд олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, нүүр царай, утас, интернэт гэх мэт аливаа аргаар хууль зүйн зөвлөгөө авах боломжийг хангах ажлыг зохион байгуулах	

Зорилт 4.1. Санхүүгийн боловсролыг нэмэгдүүлнэ

Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зан үйл, дадлын талаар олон нийтэд тогтмол мэдээлэх, мэдэгдэл, зөвлөмж өгөх, гэмт хэрэг, зөрчилд өртөх эрсдэлийн талаар таниулах, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, үйлдэгдэхээс өөрийгөө болон бусдыг хамгаалах зан суртахуун, дадал, чадварыг бий болгоход чиглэгдсэн арга хэмжээг авах.

Зорилт 4.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх

Өөрийн үйл ажиллагааны онцлог, зан үйл, дадлаас хамааран гэмт хэрэг, зөрчилд өртөх, түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болзошгүй хүн, хуулийн этгээдийн хүрээг тодорхойлох аргачлал боловсруулах, гэмт хэрэг, зөрчлийг өдөөж болзошгүй шалтгаан, нөхцөлийг тогтоож, тэдгээрийг саармагжуулах, арилгах арга хэмжээг авах зохицуулалтыг бий болгох.

Зорилт 4.3. Хууль, тогтоомжийн хүртээмжийг нэмэгдүүлэх

Гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн нийгмийн хор аюулыг олон нийтэд таниулах ажлыг тасралтгүй явуулах, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх, гэмт хэрэг, зөрчлийг хянан шалгах болон түүнд хяналт тавих үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх, хохирол, хор уршгийг нөхөн төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх, шударга ёсны тогтолцоонд олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, нүүр царай, утас, интернэт гэх мэт аливаа аргаар хууль зүйн зөвлөгөө авах боломжийг хангах ажлыг зохион байгуулах.

Зорилго 5. Ёс зүй, цогц чадамжтай хянан шалгагчийг бэлтгэж хяналт шалгалтын чанар, үр ашгийг дээшлүүлнэ.

Хүснэгт 7. Зорилго 5-ын хүрээнд хийгдэх үйл ажиллагаа

Зорилт 5.1	Зорилт 5.2	Зорилт 5.3
Ёс зүй, цогц чадамжтай хянан шалгагчийг бэлтгэх суурь тогтолцоо бий болгох	Хянан шалгагчийн сонгон шалгаруулалтыг бий болгох	Өндөр ур чадвартай, чадварлаг, туршлагатай хянан шалгагчийг татах, хадгалах нөхцөлийг бүрдүүлэх
Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа
<ul style="list-style-type: none">- Хянан шалгагчийн эзэмшвэл зохих ёс зүй, мэргэжлийн ур чадварыг тодорхойлох- Ёс зүй, цогц чадамжтай хянан шалгагчийг бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг бий болгох- Шаардлагатай их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгуулах ажлыг зохион байгуулах- Хянан шалгагчийн сургалтын институт бий болгох	<ul style="list-style-type: none">- Шинээр томилогдох хянан шалгагчийн сонгон шалгаруулалтын ангилал, түвшнийг оновчтой тодорхойлох- Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахтай холбогдох зохицуулалтыг бий болгох	<ul style="list-style-type: none">- Хянан шалгагчийн ажлын ачааллыг оновчтой тодорхойлох, тохирсон орон тоог тогтоох- Хянан шалгагчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх, цалин хөлс, нийгмийн баталгааг хангаж тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх- Хянан шалгагчдын мэдлэг чадварт, онцгой ач холбогдол өгч тасралтгүй чадавхжуулж, өсөлт зөвлөсөн чадварлаг хянан шалгагч нарыг бэлтгэх

Зорилт 5.1. Ёс зүй, цогц чадамжтай хянан шалгагчийг бэлтгэх суурь тогтолцоо бий болгох:

Цогц чадамжтай хянан шалгагчийн зан төлөв, ёс зүйн өндөр төлөвшил, туршлага, үнэт зүйл, хувь хүний хөгжил, мэдрэмж, мэргэжлийн ур чадварыг тодорхойлох, хянан шалгагчийн эзэмшвэл зохих мэргэжлийн ур чадварыг тодорхойлох, ёс зүй, цогц чадамжтай хянан шалгагчийг бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг бий болгох, шаардлагатай их, дээд сургуулиудын

сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгуулах ажлыг зохион байгуулах, хянан шалгагчийн сургалтын институт бий болгох.

Зорилт 5.2. Хянан шалгагчийн сонгон шалгаруулалтыг бий болгох:

Шинээр томилогдох хянан шалгагчийн сонгон шалгаруулалтын ангилал, түвшнийг оновчтой тодорхойлох, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахтай холбогдох зохицуулалтыг бий болгох.

Зорилт 5.3. Өндөр ур чадвартай, чадварлаг, туршлагатай хянан шалгагчийг татах, хадгалах нөхцөлийг бүрдүүлэх:

Хянан шалгагчийн ажлын ачааллыг оновчтой тодорхойлох, тохирсон орон тоог тогтоох, хянан шалгагчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх, цалин хөлс, нийгмийн баталгааг хангаж тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хянан шалгагчдын мэдлэг чадварт, онцгой ач холбогдол өгч тасралтгүй чадавхжуулах, олон улсын сургалтад сургалтад хамруулах, дэвшилтэд технологид суурилсан ухаалаг санхүүг хянах, зохицуулалттай этгээдийг эрсдэлээс хамгаалж, өсөлт зөвлөсөн чадварлаг хянан шалгагч нарыг бэлтгэх.

Зорилго 6. Хяналт шалгалтын мэдээллийн ил тод байдлыг хангаж шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хүснэгт 8. Зорилго 6-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа

Зорилт 6.1	Зорилт 6.2	Зорилт 6.3
Хорооны хяналт шалгалтын цахим нэгдсэн санг бий болгох	Хорооны хяналт шалгалтын үр дүнд бий болсон шийдвэрийг ил тод болгох	Шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болох судалгаа хийх
Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа
-Хяналт шалгалт, зөрчлийн цахим нэгдсэн санг үүсгэх -Санд мэдээлэл төвлөрүүлэх, хянах, нэгтгэх, ашиглах, мэдээллийн хадгалалт, аюулгүй байдал хангах үйл ажиллагааны зохицуулалтын журам, ашиглах зааврыг боловсруулах.	-Хяналт шалгалтын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байлгах, хууль, тогтоомжийг нэг мөр, зөв хэрэглэх, жишиг тогтоох зорилго бүхий цахим хуудсыг бий болгох -Хяналт шалгалтын үр дүнд бий болсон бүхий л шийдвэрийг нийтлэх буюу цахим хуудсанд байршуулах зохицуулалтын журам, ашиглах зааврыг бий болгох.	-Хангагдаагүй хууль эрх зүйн хэрэгцээ /хуулийн цоорхой/-г тодорхойлох судалгааг тогтмол гаргах -Санхүүгийн зах зээл болон зах зээлд оролцогчдын цаг хугацааны явцад өөрчлөг-дөж буй хэрэгцээг мэдрэх судалгаа хийх

Зорилт 6.1. Хорооны хяналт шалгалт, зөрчлийн цахим нэгдсэн санг бий болгох

Мэдээлэл нийлүүлэгч нь Хороо, төрийн бусад байгууллага, зохицуулалтын байгууллагууд байх хяналт шалгалтын үр дүнд бий болсон тайлан, байцаагчийн шаардлага, мөн хариуцлага ногдуулсан шийдвэрүүд, шийтгэлийн мэдээлэл зэргийг хуулийн этгээд, холбогдох эрх бүхий албан тушаалтны хамт бүртгэх хяналт шалгалтын цахим нэгдсэн санг бий болгох, тус санд

мэдээлэл төвлөрүүлэх, хянах, нэгтгэх, ашиглах, мэдээллийн хадгалалт, аюулгүй байдал хангах үйл ажиллагааны зохицуулалтын журам, ашиглах зааврыг боловсруулах.

Зорилт 6.2. Хорооны хяналт шалгалтын үр дүнд бий болсон шийдвэрийг ил тод болгох

Хяналт шалгалтын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байлгах, хянан шалгагч, эрдэмтэн, багш, судлаач, шинжээч, хуульчдад судалгааны ажил хийх, оюутан сурагчдад гарын авлага болгох, хууль, тогтоомжийг нэг мөр, зөв хэрэглэх, жишиг тогтоох мөн аюулгүй санхүүгийн зах зээлийг бий болгох зорилго бүхий цахим хуудсыг бий болгох, хяналт шалгалтын үр дүн бий болсон бүхий л шийдвэрийг нийтлэх буюу цахим хуудсанд байршуулах, зохицуулалтын журам, ашиглах зааврыг бий болгох.

Зорилт 6.3. Шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болох судалгаа хийх

Хангагдаагүй хууль эрх зүйн хэрэгцээ /хуулийн цоорхой/-г тодорхойлох судалгааг тогтмол гаргаж, холбогдох газруудад хүргүүлэх, зах зээлийн чиг хандлагын судалгааг хийх, судалгаанд үндэслэн хяналт шалгалтын хүрээг тодорхойлох ажлыг зохион байгуулах.

2.5. Бодлогын суурь түвшин, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт

Бодлогын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хянаж, хэмжих боломжит тоон болон чанарын үзүүлэлтүүдийг сонгож авах болно.

Хорооны хяналт шалгалтын бодлогын шалгуур үзүүлэлтийн суурь түвшинг бодлого боловсруулсан 2021 оны үзүүлэлтээр сонгох ба зорилтот түвшинг бодлогыг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа тоон болон чанарын үзүүлэлтийг тооцож төлөвлөх болно.

Тус бодлогын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг Хорооны хяналт шалгалтын богино болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлийг үнэлэх болно.